



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/9/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	10



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд. 03.13 № 294

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520206



Үүрэг, хариуцлага

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Зоригтхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын хог хаягдлыг зайлуулах.
- Нийтийн эзэмшлийн засвар үйлчилгээг хариуцах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашигладаггүй байна.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 47,749.6 мянган төгрөгөөс тооцон 477.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 529.3 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд орлогын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,471.7 мянган төгрөгөөр буюу 44,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,724.4	5,768.2	3,043.8
Авлага	-	-	
Бараа материал	-	-	
Үндсэн хөрөнгө	5,996.8	5,996.8	-
Хуримтлагдсан элэгдэл	-3,136.0	-3,707.1	-571.1
Нийт хөрөнгө	5,585.2	8,056.9	2,471.7
Өр төлбөр	-	-	
Хуримтлагдсан ашиг	5,585.2	8,056.9	2,471.7
Засгийн газрын оролцоо /эздийн өмч/	-	-	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,585.2	8,056.9	2,471.7

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн/буурсан бичилт хийгдээгүй байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 40,357.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлуулан үйл ажиллагааны зардалд зарцуулахаар батлуулсан байна.

Гүйцэтгэлээр 52,931.6 мянган төгрөгийн орлоготой, 49,887.8 мянган төгрөгийг зардалтай ажиллан, 2,471.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.



2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 1 зөвлөмж өгсөн нь хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2 724 425,60	5 768 236,95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2 724 425,60	5 768 236,95
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2 724 425,60	5 768 236,95
3121	Төгрөг	2 724 425,60	5 768 236,95
31213	Арилжааны банк дахь харилцах	2 724 425,60	5 768 236,95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 860 811,00	2 288 648,67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 860 811,00	2 288 648,67
392	Биет хөрөнгө	2 860 811,00	2 288 648,67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2 858 773,00	2 858 773,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(476 462,00)	(952 924,33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	957 000,00	957 000,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(478 500,00)	(574 200,00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5 585 236,60	8 056 885,62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5 585 236,60	8 056 885,62
51	Засгийн газрын хувь оролцоо	5 585 236,60	8 056 885,62
512	Хуримтлагдсан үр дүн	5 585 236,60	8 056 885,62
51210	Өмнөх үеийн үр дүн	5 404 805,80	5 585 236,60
51220	Тайлант үеийн үр дүн	180 430,80	2 471 649,02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5 585 236,60	8 056 885,62

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47 749 564,80	52 931 620,35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47 749 564,80	52 931 620,35
120	Нийтлэг татварын бус орлого	47 749 564,80	52 931 620,35
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	47 749 564,80	52 931 620,35
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	47 569 134,00	50 459 971,33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47 569 134,00	50 459 971,33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47 569 134,00	50 459 971,33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11 838 449,00	21 914 746,00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	11 838 449,00	21 914 746,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1 391 254,00	2 376 979,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1 391 254,00	2 376 979,00
2104	Хангамж, бараа материалын зардал	33 331 069,00	25 596 084,00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7 002 900,00	11 482 040,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	26 328 169,00	14 114 044,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 008 362,00	572 162,33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1 008 362,00	572 162,33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	180 430,80	2 471 649,02
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	180 430,80	2 471 649,02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	180 430,80	2 471 649,02



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	47 749 564,80	52 931 620,35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47 749 564,80	52 931 620,35
120	Нийтлэг татварын бус орлого	47 749 564,80	52 931 620,35
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	47 749 564,80	52 931 620,35
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	46 560 772,00	49 887 809,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46 560 772,00	49 887 809,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46 560 772,00	49 887 809,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11 838 449,00	21 914 746,00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	11 838 449,00	21 914 746,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1 391 254,00	2 376 979,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1 391 254,00	2 376 979,00
2104	Хангамж, бараа материалын зардал	33 331 069,00	25 596 084,00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7 002 900,00	11 482 040,00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	26 328 169,00	14 114 044,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1 188 792,80	3 043 811,35
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1 188 792,80	3 043 811,35
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1 535 632,80	2 724 425,60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2 724 425,60	5 768 236,95

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			5 404 805,80	5 404 805,80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0,00	0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	5 404 805,80	5 404 805,80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн			180 430,80	180 430,80
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	5 585 236,60	5 585 236,60
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	5 585 236,60	5 585 236,60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	5 585 236,60	5 585 236,60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
D08	Тайлант үеийн үр дүн			2 471 649,02	2 471 649,02
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	8 056 885,62	8 056 885,62

